

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.1. Төслийн нэр	4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч	4
2.3. Төслийн байршил	4
2.4. Уурхайн нөөц	6
2.5. Хүчин чадал	6
2.6. Уурхайн ажлын горим	6
2.7. Ашиглалтын систем	6
2.8. Уурхайн тэсэлгээ	6
2.9. Өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоо	6
2.10. Нэвтрэлтийн үеийн ачилт ба тээвэрлэлт	7
2.11. Нэвтрэлтийн бэхэлгээ	7
2.12. Босоо гол амны тоноглоогоо	7
2.13. Баяжуулах хэсэг	7
2.14. Барилга байгууламжууд	8
2.15. Цахилгаан хангамж, гэрэлтүүлэг	8
2.16. Усан хангамж	9
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	13
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	15
БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	19
6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	24
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	25
ДҮГНЭЛТ	26
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	27

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол	4
Хүснэгт 3. Өрөмдлөг тэсэлгээний ажлаар гүйцэтгэх уулын ажлын хэмжээ	6
Хүснэгт 4. Уурхайн төмөр замын үзүүлэлт	7
Хүснэгт 5. Дэр модны үзүүлэлт	7
Хүснэгт 6. Уурхайн барилга байгууламж	8
Хүснэгт 7. Уурхайн нийт усны хэрэглээ	9

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт 9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	23
Хүснэгт 14. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	24
Хүснэгт 15. 2026 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал.....	25

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордын байршлын зураг.....	5
Зураг 2. Далд уурхайн харагдах байдал.....	5
Зураг 3. Гар ялгалтын баяжуулалтын схем	8

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны орд төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд энэхүү уурхайн талаарх мэдээлэл, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж байгаа орчин, байгаль орчны төлөв байдал, төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаарх товч тодорхойлолт, баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгасан.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

Тус төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“ЭБГ” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг **11 дүгээр сарын 01-ний** дотор энэхүү журмын 2-р хавсралтын дагуу гаргаж, төсөл хэрэгжүүлж байгаа Хэнтий аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, нийслэлийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажилуулан дүгнэлтийг **12 дугаар сарын 1-ний** дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“ЭБГ” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9019064138
3	Уурхайн нэр		“Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Хэнтий аймаг
5		Сум/Дүүрэг	Батноров
6	Ашигт малтмалын төрөл		Хайлуур жонш
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-013414 MV-021835
8	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Хэнтий аймаг
9		Сум/Дүүрэг	Батноров
10		Баг/Хороо	
11	Захирлын хаяг	Нэр	Захирал
12		Гар утас	976-

2.1. Төслийн нэр

“Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч


“ЭБГ” ХХК

2.3. Төслийн байршил

Хайлуур жоншны “Идэрмэг”, “Идэрмэг 2” орд нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 410 км, Өндөрхаан хотоос зүүн хойд зүгт 70 км, Батноров сумаас баруун урд зүгт 45 км, Бэрх тосгоноос баруун урд зүгт 20 км зайд оршдог.

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол

№	Тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн нэр	Талбайн хэмжээ, га	Солбилцол	
			Өргөрөг	Уртраг
1	MV-013414 “Идэрмэг 1”	48.38	111° 5' 11.91"	47° 34' 11.76"
2			111° 5' 11.91"	47° 34' 36.77"
3			111° 4' 41.9"	47° 34' 36.75"
4			111° 4' 41.9"	47° 34' 11.76"
1	MV-021835 “Идэрмэг 2”	194.58	111° 6' 0.0"	47° 35' 0.0"
2			111° 4' 41.9"	47° 35' 0.0"
3			111° 4' 41.9"	47° 34' 36.75"
4			111° 5' 11.91"	47° 34' 36.77"
5			111° 5' 11.91"	47° 34' 11.76"
6			111° 6' 0.0"	47° 34' 11.76"



Зураг 1. “Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордын байрилын зураг



Зураг 2. Далд уурхайн харагдах байдал

2.4. Уурхайн нөөц

Ашиглалтын систем ба технологийн дагуу “Идэрмэг болон Идэрмэг 2” ордоос 64.89 %-ийн дундаж агуулгатай нийт 107.95 мян.тн хүдэр олборлохоор байна.

2.5. Хүчин чадал

Ордын уул-техникийн нөхцөлөөр жилийн хүчин чадлын хэмжээ нь хүдрийн хаягдал ба бохирдлын хэмжээнээс хамаарч 26172.0-34574.7 тн хүдэр болж байна. Дээрх тооцооноос харахад жилийн дундаж хүчин чадал **31.38 мян.тн** хүдэр байна.

2.6. Уурхайн ажлын горим

Жилд ажиллах хоногийн тоо 300 байна. Уулын ажлыг газрын дор ажиллах далд уурхайн хэсэгт 7 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр, газрын дээр ажиллах хэсэгт 8 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллана.

2.7. Ашиглалтын систем

“Идэрмэг болон Идэрмэг 2” хайлуур жоншны ордын В зэрэглэлээр бодогдсон нөөцийг ашиглахаар тооцсон байна. Дээрх хүдрийн биет нь 90° уналтай, 1.1 м дундаж зузаантай, ашиглалтын гүн дунджаар 120.0 м байна. Ордын уул-геологийн нөхцлөөс харахад хүдэр хоршоолох ашиглалтын систем хамгийн тохиромжтой байна.

2.8. Уурхайн тэслэгээ

Чулуулгийг тэслэх ажилд манай оронд өргөн хэрэглэгдэж байгаа ОХУ-д үйлдвэрлэсэн патронон тэсрэх бодис Аммонит 6ЖВ-г сонгов. Тэслэгээг галаар болон цахилгаанаар гүйцэтгэнэ. Босоо малталтыг цахилгааны аргаар, хэвтээ малталтыг галаар тэслэнэ.

2.9. Өрөмдлөг тэслэгээний ажлын тооцоо

Хүснэгт 3. Өрөмдлөг тэслэгээний ажлаар гүйцэтгэх уулын ажлын хэмжээ

Д/д	Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1	УҮА	Босоо гол ам	м ³	1227.6
		Квершлаг	м ³	1029.6
		Гол ам орчмын малталт	м ³	369.1
		Тээврийн штрек	м ³	2913.1
		Сэлгээний орт	м ³	82.8
		ТБ-ын түр агуулах	м ³	70.7
		Нийт	м ³	5692.9
	УБА	Восстаюший	м ³	2652.0
		Ачилтын орт	м ³	1472.0
		Блокийн цонх	м ³	1536.2
		Нийт	м ³	5660.2
3	Хүдэр нураалт	Огтолгооны штрек	м ³	3061.9
		Туузны нураалт	м ³	18696.2
		Нийт	м ³	21758.2
Нийт уулын цулын хэмжээ, м ³			м ³	33111.2

2.10.Нэвтрэлтийн үеийн ачилт ба тээвэрлэлт

Далд уурхайн дотоод тээврийг 0.8 м³-ийн тэвшний багтаамжтай тэргэнцрээр гүйцэтгэнэ. Z-17AW маркийн утгуурт ачигчаар ачилтыг явуулах ба уулын цулыг YR315M2-8 маркийн хөдөлгүүртэй, босоо гол амны өргөх төхөөрөмжийн тусламжтай газрын гадаргууд татаж гаргана.

Уурхайн төмөр замын үзүүлэлт:

Хүснэгт 4. Уурхайн төмөр замын үзүүлэлт

Зам төмрийн төрөл	Хэмжээс, мм				Хөндлөн огтлолтын талбай, см ²	Масс, кг	Зам төмрийн урт, м
	Өндөр	Өргөн					
		Ул	Толгой	Ханын зузаан			
P18	90.0	80.0	40.0	10.0	29.07	18.86	8

Дэр модны үзүүлэлт:

Хүснэгт 5. Дэр модны үзүүлэлт

Төрөл	Дэр модны төрөл	Зузаан, см	Өргөн, см		Урт, мм
			Дээд тал	Доод тал	
P18	Дүнз	12.0	10.0	18.8	1200.0

2.11.Нэвтрэлтийн бэхэлгээ

Уурхайд босоо гол ам, блокийн восстаюшийг зайлшгүй бэхлэх шаардлагатай. Ачилтын ортууд, квершлаг, тээврийн штреткийн уулзварыг нуралт, хагарал байхгүй тохиолдолд бэхлэх шаардлагагүй.

2.12.Босоо гол амны тоноглоогоо

Гол амыг дараах 3 хэсэгт хувааж тоноглоогооны ажлыг гүйцэтгэнэ.

- 1-р хэсэг: Хүн явах зориулалттай, бэхэлгээний дотор талын хэмжээгээр 1.2 м Ч1.7 м хөндлөн огтлолын талбайтай байна.
- 2-р хэсэг: Агааржуулах хоолой, ус болон хийн хоолой, цахилгаан ба холбооны шугам явах зориулалт бүхий 1.2 м Ч 0.8 м хөндлөн огтлолын талбайг гаргаж өгнө.
- 3-р хэсэг: Ажилтан, ашигт малтмал, тоног төхөөрөмж тээвэрлэх зориулалт бүхий 1.7 мЧ1.8 м хэмжээтэй байна.


2.13.Баяжуулах хэсэг

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Идэрмэг болон Идэрмэг 2” хайлуур жоншны ордуудын төсөлд хүдрийн найрлага, шинж чанар, технологийн туршилт, гар ялгалтын судалгааны үр дүнд үндэслэн хүдрийг гараар ялгаж МБФ-80 маркын бүхэллэг жонш ялган борлуулж үлдэгдэл ядуу агуулгатай хүдрийг зэргэлдээх хүдэр баяжуулах үйлдвэрт нийлүүлэхээр тусгасан.

Жоншны хүдэр гар аргаар баяжуулах технологи:

“Идэрмэг болон Идэрмэг 2” хайлуур жоншны хүдэр баяжуулах технологийн оновчтой хувилбарыг төсөл захиалагчийн техникийн даалгавар болон 2021 онд Геологийн төв лабораторит гүйцэтгэсэн хүдрийн баяжигдах шинж чанарын судалгааны үр дүн зэргийг үндэслэн уг ордын

хүдрийг гар аргаар ялган баяжуулж, 80%-ийн CaF_2 -ийн дундаж агуулгатай баяжмал гарган авах мөн үлдэгдэл хүдрийг Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших баяжуулах үйлдвэрт нийлүүлэхээр тооцсон байна.



Зураг 3. Гар ялгалтын баяжуулалтын схем

2.14.Барилга байгууламжууд

Хүснэгт 6. Уурхайн барилга байгууламж

Барилга байгууламжийн нэр	Материал
а. Үйлдвэрийн барилга байгууламж	
Контор	сэндвич
Засвар механикийн цех	сэндвич
Баяжуулах цехийн барилга байгууламж	сэндвич
Сэлбэгийн агуулах	сэндвич
Гараж	Хоосон чулуу
Тэсрэх материалын агуулах	тоосго
ШТМ-ын агуулах	емкость
Гол амны байгууламж	Мод, тоосго
Дүн	
б. Иргэний барилга байгууламж	
Ажилчдын байр	сэндвич
Хоолны байр	сэндвич
Халуун ус, жорлон	сэндвич

2.15.Цахилгаан хангамж, гэрэлтүүлэг

Уурхайн цахилгаан хэрэглэгч нь 1. Далд уурхай; 2. Өргөх хэсэг; 3. Компрессорын станци; 4. Механик цех; 5. Уурхайн гэрэлтүүлэг; 6. Тэсрэх материалын агуулах; 7. Уурхайн тосгон зэрэг байна. Энэхүү цахилгаан ачааллын тооцоогоор гарсан 380.0 кВА актив цахилгаан ачаалал, чадлын коэффициент зэргийг үндэслэн 400кВт-н хүчин чадалтай Volvo TAD1641GE маркийн дизель станцыг сонгож авлаа.

Гэрэлтүүлэг: Далд уурхайн гэрэлтүүлгийг босоо гол ам, квершлаг, тээврийн штрекийг гэрэлтүүлэхээр тооцоолж тоног төхөөрөмжийг сонголоо. Уг тооцоог хийж гүйцэтгэхдээ гэрэлтүүлгийн хэмжээг тооцож босоо аманд 5 ширхэг, квершлагт 8 ширхэг (гол ам орчмын

малталт орсон), тээврийн штрөкэд 25 ширхэг, РВЛ-15 маркийн гэрэлтүүлэгчийг 25 м-ийн зайтай угсарсан байна.

2.16. Усан хангамж

Далд уурхайн усан хангамжийг уурхайд гаргасан гүний худгаас 5 тн багтаамжтай цистернээр зөөвөрлөж гүйцэтгэнэ.

Нийт усны хэрэглээ:

Хүснэгт 7. Уурхайн нийт усны хэрэглээ

Ажиллах хугацаа	Усны хэрэглээ				
Х.нэгж	Унд ахуйн ус, м³	Замын усалгаа, м³	Ногоон байгууламж, м³	Нийт	Шаардлаатай усны эх үүсвэр, л/с
1 дэх жил	2208	0.00	0	2208	0.212
2 дахь жил	2208	75.60	96.0	2379.6	0.091
3 дахь жил	2208	75.60	96.0	2379.6	0.091
4 дэх жил	2208	75.60	96.0	2379.6	0.091
Нийт	8,832.00	226.80	288.0	9,346.80	0.488

Хайлуур жоншны ордын ашиглалтын 4 жилийн хугацаанд унд, ахуйн хэрэгцээнд 8,832.0 м³, зам талбайн усалгаанд 226.80 м³, ногоон байгууламжийн усалгаанд 288.0 м³ ус ашиглахаар тооцоо гарсан байна. 4 жилийн хугацаанд нийт 9,346.8 м³ ус ашиглахаар байгаа ба нийт 0.48 л/с усны ундрага шаардлагатай байгаа бөгөөд 0.5 л/с худгийн усны ундрага хүрэлцээтэй байна.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газарзүйн байрлал, газрын гадарга:

Физик газарзүйн мужлалтын хувьд Хангай-Хэнтийн уулархаг их мужид хамаарна.

Хэнтий нурууны өмнөд шувтрага хэсэгт харьцангуй бага хэрчигдэлтэй ойн модгүй хээрийн бүсэд хамаарна. Газрын гадаргуугийн хувьд дэнд зэргийн уулархаг тал бөгөөд 900-1400 м-ийн өнөдрлөгийн хооронд хэлбэлздэг.

Тус талбайн уул нурууд нь мөлгөр тэгш оройтой хоорондоо зэрэгцээ байрлалтай урт нарийн хөндий, хөтлөөр тусгаарлагдсан хэд хэдэн уул нуруудаас тогтоно. Эдгээр хөндий хотгорууд нь 1,0-5,0 км өргөнтэй, 3-5 хэмийн налуу бэл үүсгэнэ. Хөндий хотгоруудын дунд нуур, тойрмууд үүссэн байдаг.

Үндсэн чулуулгийн гарш дунд зэрэг, ихэвчлэн толгодын орой, хяраар ажиглагддаг намхавтар уулсын орой, хажууд 1-1,5м зузаантай, уулсын хормой, голын хөндийд 10м зузаантай сэвсгэр хурдас тархсан байдаг.

Цаг агаар:

Энэ газар нь өвөл урт, зун богино байдаг. Сүүлийн 10 жилийн судалгаанаас үзэхэд хамгийн их хүйтрэлт 12,1,2 дугаар саруудад тохиолдох ба дээд тал нь -27,2-44.3°C хүрсэн байхад хамгийн дулаан сар болох 6,7,8 дугаар саруудад агаарын хамгийн их температур +17-+38.5°C хүрсэн байна. Сарын дундаж агаарын температур ууландаа 1 сард -22-30°C, 7 сард +13-+18°C, уул хоорондын хөндийд +15-+20°C хүрдэг. Хавар оройн хүйтрэлт 6-р сарын 2-ноос 6-р сарын 11-ний хооронд, намар эртийн хүйтрэлт 8-р сарын 26-наас 9-р сарын 4-ны хооронд, өвөл 12-р сарын 5-10-ны үед тогтвортой цасан бүрхүүл үүсч 3-р сарын 15-25 хүртэл үргэлжилдэг. Цасан бүрхүүлийн гүн тэгш талаараа 20см, бусад газар 30-60см, түүнээс ч илүү байдаг. Хур тунадас 5-9 дүгээр саруудад дунджаар 156-482мм-ийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд ургамал ургалтын хугацаанд жилд дунджаар 304мм хур тунадас ордог. Ургамал ургалтын хугацаа 151 хоног.

Усан орчин:

Хэнтий аймгийн нутаг дэвсгэр нь ус зүйн хагалбараар Номхон далайн ай савд багтана. Хэнтий аймгийн Батноров сум нь Хэрлэн голын ай сав газрын бүсэд хамаарна.

Хэнтий аймгийн нутгаар Хэрлэн гол 580 орчим км цутгадаг ба түүний цутгал Тэнүүн, Тэрэлж, Мөрөн, Цэнхэр, мөн Онон гол 390 гаруй км урсах бөгөөд түүний цутгалууд Хурх, Шуус, Барх, Балж болон Улз голууд урсана. Нууруудын хувьд Гурваннуур, Хар зүрхний Хөх нуур, Гүрмийн нуур, Аваргын нуур болон Хэрлэнгийн савд жижиг жижиг нуурууд олон байдаг.

Тус аймаг нь манай орны рашаан ус элбэгтэйд тооцогддог. Гурван нуур, Улаалзгана, Онон, Тард, Арангат, Тосон нуур зэрэг рашаан ус байдаг. Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Норовлин, Дадал сумын нутаг дэвсгэрийг дамжин урсдаг Онон, Хэрлэн, Улз гол Номхон далайн ай савд, Өмнөдэлгэр сумын нутаг Минж гол, түүний цутгал голууд Хойд мөсөн далайн ай савд, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд Дархан, Галшар сумын багахан нутаг дэвсгэр хамрагддаг.

Хайлуур жоншны ордын урд хэсгээр 3 км зайд Хэрлэн гол урсаж байна.

Хөрс:

Хөрсний мужлалын хувьд Хангайн их муж түүн дотроо Хэнтий мужид багтах ба газар зүйн байршлын хувьд Хэнтийн гол нуруу түүнээс тал бүр тийш салбарласан уулс аажим намссаар бэсрэг уулс болон улмаар ухаа гүвээ, талд шилжинэ. Уулт ойт хээрийн, уулын ойн саарал ба уулын хээрийн хүрэн хөрсний бүслүүрт хамаарна. Уулын ар хажууд 1400 метрийн үнэмлэхүй өндөр хүртэл хар хүрэн, хүрэн хөрс 1400-1600 метрт уулын хар шороон хөрс түүнээс дээш өндөр (1800-2200 метр)-т уулын ойн саарал ба уул тайгын ширэгт чандруувтар хөрс тус тус тархаж, уулын хавтгайдуу оройд уулын нугын хүлрэнцэр нимгэн хөрсөөр солигддог байна.

Монгол орны хөрсний ангиллаар тус сав газар нь уулын хөрсний бүлэгт багтах уулын хээрийн хар шороон хөрс бага зэрэг, хүрэн шороон хөрс, тал хөндийн бүлгийн хуурай хээрийн ба хээрийн хөрс зонхилон тархсан байна. Тус сав газарт бэлчээрийн талхагдлаас болж нилээд газарт хөрсний өнгөн үеийн бүтэц алдагдсан байна.

Ургамал:

Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евразийн хээрийн их муж Дагуур-Монголын (Төв азийн дэд их муж) Дагуур Монголын уулын ойт хээрийн муж, дэд муж нь Онон-Хянган орчим хамаарна. (Үндэсний атлас, 1990). Бэлчээрийн ургамлан нөмрөгт судалгаа хийж, газрын төлөв байдал, ургамалжлын хэв шинжүүдийг тогтоох бичиглэл хийсэн. Судалгааны талбайн нь цөлийн хээрийн бэлчээр бөгөөд 1 бүлгэмдэлд 12 овгийн 29 төрлийн нийт 36 зүйл ургамал бүртгэгдсэн.

Амьтан:

Хэнтий аймагт сээр нуруутны төлөөлөл болох 376 зүйл, сээр нуруугүйтний төлөөлөл болох 400-аад зүйл нийт 730 гаруй зүйлийн амьтад амьдарч байгааг судлаачид тогтоосон.

Тарвага, буга, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, дорго, мануул, шилүүс, туулай, чандаг зэрэг ан амьтад, шонхор, тас, сар, хур, сойр, шаазгай, ятуу, болжмор, хараацай, усны шувуудаас тогоруу, галуу, ангир, хун, нугас зэрэг жигүүртэн шувуудтай. Хэрлэн голд сөөм булуу цагаан, зэвгэ, цурхай зэрэг загастай. Тогоруу, хун, галуу, нугас, ангир зэрэг усны шувууд шар шувуу, шонхор, тас, сар, хур сойр, ятуу, болжмор, хэрээ, хараацай шувууд нутагладаг.

Нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Хэнтий аймгийн Батноров сум нь Ардын хувьсгалын дараахь Монгол улсын Засаг захиргааны шинэчлэн зохион байгуулалтаар Дайчин бэйлийн хошууг Сэргэлэн гүн, Сүжигт бэйсийн хошууны зарим хэсгийг хамруулж 1923 оны 10 дугаар Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор Батноров уулын хошуу, Одоогийн Батноров сум үүсэн байгуулагдсан. Тус сум нь нийт 496928.4 га газар нутагтай, Улаанбаатар хотоос зүүн тийш 435 км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос зүүн хойш зүгт 105 км-т оршдог. Хэнтий аймгийн Хэрлэн, Биндэр, Баян-Адрага, Норовлин, Баян-Овоо, Баянхутаг зэрэг сумдтай хиллэдэг. Сумын нутаг дэвсгэр нь баруунаас зүүн тийш 74 км, урдаас хойш 118 км-т сунаж тогтсон. Нийт 496928.4 га газар нутагтай бөгөөд Монгол орны газар зүйн бүсчлэлээр тал хээрийн бүсэд оршдог. Засаг захиргааны нэгжийн

хувьд сум нь Эрдэнэчандмань, Эхэнбүрд, Баян, Баянбулаг, Идэрмэг, Дундбүрд, Бэрх гэсэн 7 багтай. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн төрийн 6 байгууллагатай. Хүн амын хувьд 2021 оны жилийн эцсийн байдлаар 5841 хүн амтай үүнээс эрэгтэй 3002, эмэгтэй 2839, хүн амын дийлэнх 90 гаруй хувь нь халх үндэстэн бусад нь буриад, барга, баяд, дархад, дарьганга, дөрвөд, казак, торгууд урианхай зэрэг үндэстэнгүүд аж төрөн амьдардаг. Мал сүрэг нь 2021 оны жилийн эцсийн байдлаар 432757 толгой мал үүнээс Тэмээ 289, Адуу 34596, Үхэр 32548, Хонь 236198, Ямаа 129126 толгой мал тус тус тоолуулсан. Хувийн хэвшлийн 72 аж ахуй нэгж, иргэн арьс шир боловсруулах, хүнсний дэлгүүр, талх гурилан боовны цех, цагаан идээ боловсруулах, гар урлал, үсчин гоо сайхан зэрэг жижиг дунд үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Томоон уул уурхай Алтан гадас одонт Бэрхийн уурхай, Ямаатын уурхай, Хавтгайн уурхай, Чимэдийн уурхай, Баяжуулах үйлдвэр гэсэн байгалийн баялаг жонш үйлдвэрлэх, боловсруулах уурхай, үйлдвэрүүдтэй. Эдийн засгийн чадамжийн хувьд бэрхээс тусдаа төсөвтэй явдаг бөгөөд сумын нийт төсөв нь жилийн 3.2 тэрбум.төгрөг, үүнээс сумын өөрийн татварын орлого 0.2 хувийг нь бүрдүүлэн төвлөрүүлдэг.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Хэнтий аймгийн Батноров сумын нутагт байрлах “ЭБГ” ХХК нь MV-013414, MV-021835 тоот тусгай зөвшөөрөл бүхий нийт 242.96 га талбайтай. Хайлуур жоншны орд”-ыг далд аргаар ашиглах төсөл хэрэгжүүлнэ.

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Уурхайн үйл ажиллагааны үед газрын хэвлий эвдэгдэх,
- Уурхайн үйл ажиллагаагаар газрын гадарга өөрчлөгдөх,
- Уурхайн үйл ажиллагааг ТЭЗҮ төлөвлөлтийн талаар явуулахгүй байх.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тоосжилт үүсэх,
- Бутлуурын хэсэгт тоосжилт үүсэх,
- Уурхайн тэсэлгээ хийх үед дуу чимээний нөлөөлөл үүсэх,
- Тээврийн хэрэгслийн яндангаас үүсэх хорт хий утаа, тортог үүсэх,
- Хог хаягдлаас үүсэх орчны эвгүй үнэр үүсэх.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Технологийн болон унд ахуйн усыг гүний худгийн усаар хангана. Энэ тохиолдолд газрын гадаргын болон гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсгэх болно.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Технологийн процесс, тоосжилтыг дарахад ашиглах болон ундны усыг гүний худгаас хангах учир гүний усны нөөцөд бага хэмжээний өөрчлөлт оруулна.
- Түлш шатахуун, шатах тослох материалууд, бохир ус алдагдсанаас үүдэн бага гүнд орших уст давхарга бохирдох.
- Газрын доорх усан орчин бохирдсон тохиолдолд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлнө.

Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс олон салаа зам үүсч хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх,
- Хөрсний шинж чанар техноген гаралтай хүчин зүйлүүдийн нөлөөгөөр элэгдэлд өртөж, хими-физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах,
- Тээвэрлэлтийн машин техникт үзлэг засвар хийх үед нефтийн бүтээгдэхүүн, шатах, тослох материал, хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах.
- Хөрс хуулах, карьерын талбайгаар хөрс сулран ургамлын нөмрөг бүр мөсөн устаж үгүй болно.
- Ажилчдын суурингийн эргэн тойрон, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн улмаар тоног төхөөрөмжийг газрын гадарга дээр засварлах, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн зэргээс хөрс талхлагдан, ургамлын төрөл зүйл, ургалт доройтно.

- Олборлолтын үеийн шороо тоос орчны ургамалжилтанд нөлөөлж, ургалт удааширна.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Олборлолтын талбайд ямар нэгэн шавжийн бүлгэмдэл, хөхтөн амьтад байхгүй. Олборлолт хийж байгаа газарт болон хаягдал овоолох талбайд байршиж байгаа шавж идэштэн, мэрэгч амьтдын нүх оромж, орчинтойгоо устаж үгүйрнэ,
- Дуу шуугиан, машин техник болон хүний хөл хөдөлгөөн ихсэх зэргээс улбаалан, ан амьтад, шувууд үргэн дайжиж, тархалт байршилт нь өөрчлөгдөнө,
- Уурхайн ухсан нүх суваг, шуудуу руу мал амьтан уурхайн талбай руу унаж, бэртэх аюултай.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:

- Уурхайн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай,
- Уурхайн ажлын үед ашиглаж буй техник, машин механизмаас дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн ам, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ,
- Уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлийн дуу чимээ, тоосжилт ихэссэнээр хүн ам болон ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Уурхайд ажиллагсдыг хортой, хүнд нөхцөлд ажилладаг учир эрүүл мэндэд эрсдэл учрах аюултай.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“ЭБГ” ХХК-ийн “Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан.

Энэхүү БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“ЭБГ” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 33,063,000 сая.төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

“Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордын үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг, / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	- Олборлолтын үед тоосжилт үүсэх, -Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх	Тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийх, техникийн үзлэгт оруулах.	Тээврийн хэрэгсэл	-	60,000	4	240,000	Жил бүр	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2007. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, -MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга.
2	тоосжилт, -Тэсэлгээний үед үүсэх тоосжилт, - Техник тоног төхөөрөмж, хүнд машин механизм, тээврийн хэрэгслийн яндангаас хаягдах бодисоор агаар бохирдох гол сөрөг нөлөөлөл.	Уурхайн тээвэрлэлтийн зам, уурхай орчимд тоосжилт дарах усалгааг тогтмол хийх	Тээвэрлэлтийн зам	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	4,5,6 сард 7 хоногт 1 удаа хийх.	

Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрс элэгдэл эвдрэлд өртөх, -ШТМ асгарч газрын гадарга хөрсийг бохирдуулах.	Тээврийн хэрэгслийг тогтсон нэг замын маршрутаар явуулах, замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах.	Уурхайн зам	-	-	-	1,500,000	Уурхайн үйл ажиллагаа-ны үед	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, - MNS 3310-91, Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох, - MNS 17.5.1.19-92, БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах шаардлага, - MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
3		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах багаж хэрэгслийг бэлэн байлгах	ШТМ	-	-	-	500,000	Тухай бүрт	
4		Шатах тослох материалыг хадгалах талбайг хатуу хучилттай болгох.	ШТМ-ын талбай	-	-	-	2,500,000	2026 онд	
5		Уурхайн талбайд хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, уурхайн орчны цэвэрлэгээг тогтмол хийх	Хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	
Усан орчин									
1	-Гүний худгийн усны хомсдол үүсэх, - Гүний худгийн ус бохирдох, -Шатах тослох материал хур тунадас болон үерийн усаар угаагдан гадаргын болон хөрсний бага	Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх	Ахуйн бохир ус	-	-	-	-	Тогтмол	-Усны тухай хууль, -Ус ашигласны төлбөр (2009 оны 351-р тогтоол), -MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж, -MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт -MNS 3342:1982 Усан мандал. Газар доорх усыг
2		Үерийн уснаас хамгаалах далан хаалт байгуулах	Уурхай орчим	-	-	-	-	2026 онд	
3		Гүний худгийг бохирдохоос сэргийлж, хашаалж хамгаалах	Гүний худаг	-	-	-	1,000,000	2026 онд	
4		Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай хуулийн дагуу ус ашиглалтын гэрээ байгуулан төлбөрийг тогтмол төлөх.	Ус ашигласны төлбөр	-	-	-	Гэрээний дагуу	2026 онд	

	гүний усыг бохирдуулах, -Ахуйн бохир ус алдагдаж гүний усанд нөлөөлөх.								бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
	Нийт зардал						4,000,000		

6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Уурхайн олборлолтоор 4 жилийн хугацаанд нийт 6.72 га талбай эвдрэлд өртөнө. Уурхайд нөхөн сэргээлтийг жил бүр хийх боломжгүй бөгөөд уурхайн хаалтын үе шатанд буюу 3 дахь жилээс эхлэн хийхээр төлөвлөсөн байна.

6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас санал авсны үндсэн дээр эвдэрсэн газрыг техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн.

Хүснэгт 9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутагтай хамтарч	Техникийн нөхөн сэргээлт хийх. Баянбулаг 4-р багт 0.9 га талбайд нөхөн сэргээлт хийх. (111° 38' 37.49", 47° 56' 03.71")		-	-	Дотоод төлөвлөлтөөр	2026 онд	-Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага, -БОНБНҮ-ий тухай хууль.
2	ажиллах, дүйцүүлэн хамгаалах ажил хийх санал орон нутгаас авах, хэрэгжүүлэх.	Ган, цас зудтай үед зарим газарт ан амьтанд нэмэгдэл тэжээл тавьж өгөхөд зориулан өвс тэжээл, хужир марааны нөөц үүсгэхэд хамтран ажиллах				7,000,000	2026 онд	

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Идэрмэг 1, Идэрмэг 2”
нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн
2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

3	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	Хэрлэн гол дагуу орон нутгаас тогтоосон газарт бургас тарих	-	-	-	3,000,000	2026 онд	
Нийт зардал						10,000,000		

6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй болно.

6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Далд уурхайн бэхэлгээ нурах, болзошгүй осол аваар гарах, -Галын гэнэтийн аюул үүсэх,	Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Ажилчдад	-	-	500,000	Жил бүр	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхой- лолт, ерөнхий анги, -MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
2	-Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Уурхайн ажилчид	92	-	9,200,000	Жил бүр	
3	ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх.	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, багаж хэрэгслийг нэмэгдүүлэх, сайжруулах	Уурхайн кемп орчимд	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	2026 онд	

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Идэрмэг 1, Идэрмэг 2”
нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн
2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

4	-Уурхайд тэсэлгээний үед аюул үүсэх.	Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Уурхайн удирдлага	-	-	-	Тогтмол	-MNS 12.4. 005 – 1985: Хөдөлмөр хамгаалал.Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд.
5		Аваар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Уурхайн удирдлага	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
6		Тэсэлгээг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх.	Тэсэлгээ	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2026 онд	
7		Уурхайн тэсэлгээний үед аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж ажиллах, мэргэжлийн тэсэлгээчнээр гүйцэтгүүлэх.		-	-	-	2026 онд	
Нийт зардал						9,700,000		

6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2026 он/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хатуу хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээний дагуу тогтмол зайлуулах	Хог хаягдал	-	-	-	350,000	Жилд 1 удаа	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага, -Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль.
2		Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах	Хог хаягдлын сав	-	-	-	3,000,000	2026 онд	

3	Аюултай хог хаягдал	Ашигласан шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, уурхайн орчинд асгарч алдагдахаас тухай бүр сэргийлэх, ШТМ дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх	ШТМ хадгалах сав, поошик дүүрэхээр тээвэрлүүлэх.	ш	100,000	2	200,000	Тухай бүрт	
4		ШТМ болон аюултай хог хаягдлыг хадгалах талбайг хатуу хучилттай болгох	ШТМ хадгалах талбай	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2026 онд	
5		Тэсэлгээний үед хэрэглэсэн тэсрэх бодисын сав баглаа боодлын хаягдлыг тэсэлгээний мэргэжлийн байгууллага хариуцаж, буцаан авч явж устгуулах.	Тэсрэх бодисын сав баглаа боодлын хаягдал	-	-	-	-	2026 онд	
Нийт зардал							3,550,000		

6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордыг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын орчин							
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ хийлгэх	-Далд уурхай орчмоос, -Кемп орчмоос. - Уурхайн тээвэрлэлтийн замаас.	Жилд 1 удаа	Агаарын сорьц дээж 45,000 Агаарын шинжээч – 250,000	355,000	Хэнтий аймгийн цаг уур орчны шинжилгээний харьяа лабораторит	-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,

							-MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга,
Хөрсөн бүрхэвч							
1	Агрохимийн шинжилгээ: Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	-Далд уурхай орчмоос, -Кемп орчмоос. - Уурхайн тээвэрлэлтийн замаас.	Жилд 2 удаа	25,000	150,000	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
2	Хөрсний хүнд металлын шинжилгээ: (Cr, Cd, Pb, Ni, Co, Cu)	-Кемп орчмоос. -Тээвэрлэлтийн замаас.	Жилд 2 удаа	27,000	108,000		
Усан орчин							
1	Усны химийн ерөнхий шинжилгээ: (pH, EC, TDS) нийт шүтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Унд ахуйн уснаас	Жилд 2 удаа	50,000	100,000	Усны итгэмжлэгдсэн лаборатори	-MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага, - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус- химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх, -MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга,
Нийт зардал					713,000		

6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв / 2026 он /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 онд				
			6-р сар	7-р сар	8-р сар		
1	Байгаль орчныг хамгаалах сургалтыг ажилчдад зохион байгуулах	500,000				Уурхайн удирдлага	Ажилчдад байгаль орчны талаарх мэдлэг олгох.
2	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	4,600,000		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
3	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний дагуу хамтран ажиллах, шинэчлэх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан нягт хамтран ажиллах
Нийт зардал		5,100,000					

6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

"ЭБГ" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 14. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Хэнтий аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	Тайлан хэлбэрээр, уурхайн талбайд очих.	БОМТ-ийн 2026 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ны өдрийн дотор	Уурхайд
БОУАӨЯ	БОУАӨЯ-ны ХБОБНУГ	Тайлан			БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр	2026 оны БОМТ	12-р сарын 01-ны өдрийн дотор	-

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“ЭБГ” ХХК-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2026 онд БОМТ-нд нийт **30,009,000** сая.төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 15. 2026 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2026 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	4,000,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,550,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	9,700,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5,100,000
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	713,000
Нийт дүн		33,063,000

ДҮГНЭЛТ

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “ЭБГ” ХХК-ийн “Идэрмэг 1, Идэрмэг 2” нэртэй хайлуур жоншны ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу биелэлтийн тайланг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“ЭБГ” ХХК-ийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

“Идэрмэг 1, Идэрмэг 2” хайлуур жоншны ордын БОМТ-нд 2026 онд нийт **33,063,000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“ЭБГ” ХХК нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
7. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Идэрмэг 1, Идэрмэг 2” Хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2025 он
8. <http://www.legalinfo.mn/>